



ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/471

Зуунмод

Г Зуунмод сумын зудын гамшгаас урьдчилан
сэргийлэх төлөвлөгөө боловсруулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль”-ийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.12 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Малчид болон орон нутгийн иргэдийн амьжиргааг хамгаалах, тэдгээрийн амьжиргааны эх үүсвэр болох мал сүргийг зудын гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээг тодорхойлох, гамшгийн дараа нөхөн сэргээх зудын гамшигтай тэмцэх төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Г.Батжаргал	-Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүдэд:	С.Мөнх-Амгалан	-Захирагчийн албаны ахлах мэргэжилтэн
	Г.Уянга	-Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн
	Д.Өнөрбаяр	-Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн
	Э.Долгормаа	-Тархвар зүйч
	Д.Амартүвшин	-Хууль эрх зүйн мэргэжилтэн
	Т.Пансандулам	-Архив, бичиг хэргийн эрхлэгч
		-Багийн Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нар
Нарийн бичгийн дарга:	Б.Батжаргал	-Хөдөө аж ахуйн тасгийн дарга

2. Сумын зудын гамшигтай тэмцэх төлөвлөгөөг боловсруулан батлуулж, аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлэн ажиллахыг Ажлын хэсэг дарга, гишүүдэд даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Н.Энхсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ч.САРАНГЭРЭЛ



Zahiramj-2022-2

4122051082